



МАНДАЛ
ДААТГАЛ

2025 оны 06 сарын 10 өдөр

Дугаар 25/606

Улаанбаатар хот

“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ”-д

Компанийн хувьцааг эргүүлэн худалдан авч,
халааслах тухай

“Мандал Даатгал” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 06 сарын 09-ний өдрийн №25/007 тоот тогтоолоор компанийн нийт гаргасан хувьцааны 5 хүртэлх хувийг олон нийтээс эргүүлэн худалдан авч, халааслахаар шийдвэрлэсэн тул хавсралтаар дараах материалыг хүргүүлж байгааг хүлээн авна уу.

Хавсралтаар:

1. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоол, хавсралт – 4 хуудас

Хүндэтгэсэн,
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ Б.ЭНХТҮВШИН





МАНДАЛ
ДААТГАЛ

2025 оны 06 сарын 09 өдөр

Дугаар 25/007

Улаанбаатар хот

**МАНДАЛ ДААТГАЛ ХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

Компанийн хувьцааг эргүүлэн худалдан авч,
халааслах тухай

Компанийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1, 49.2, 49.4 болон 49.5 дах заалт, 55 дугаар зүйлийн 55.2 дах заалт, 76 дугаар зүйлийн 76.1.7 дах заалт, "Мандал Даатгал" ХК (цаашид "Компани" гэх)-ийн Дүрмийн 6 дугаар зүйлийн 6.7, 6.8 болон 6.9 дэх заалт болон компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 06 сарын 09-ны өдрийн ээлжит бус хурлын санал хураалтын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Мандал Даатгал" ХК-ийн нийт гаргасан хувьцааны 5 (тав) хүртэл хувь буюу 31,215,080 ширхэг энгийн хувьцаанаас хэтрэхгүй хэмжээний хувьцааг энэхүү тогтоолын Хавсралт №1-т заасан нөхцөлийн дагуу Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтээс эргүүлэн худалдан авч, халааслахаар шийдвэрлэсүгэй.
2. "Мандал Даатгал ХК-ийн хувьцааг эргүүлэн худалдан авч, халааслах журам"-ыг энэхүү тогтоолын Хавсралт №2-оор баталсугай.
3. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэх, компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийг холбогдох мэдээллээр хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Б.Энхтүвшинд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ө. ГАНЗОРИГ

Хаяг:

Шуудангийн хаяг:

☎ (976) 7575 2000


@ info@mandal.mn

🌐 www.mandal.mn

“Мандал Даатгал” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2025 оны 06 сарын 09-ний өдрийн ээлжит бус хурлын
№25/007 тоот тогтоолын Хавсралт №1



КОМПАНИЙН ХУВЬЦААГ ЭРГҮҮЛЭН ХУДАЛДАН АВЧ ХАЛААСЛАХ НӨХЦӨЛ		
1	Нэг өдөрт эргүүлэн худалдаж авах хувьцааны тооны дээд хязгаар	Төлөөлөн Удирдах Зөвлөлийн эргүүлэн худалдаж авахыг зөвшөөрсөн нийт энгийн хувьцааны 31,215,080 (гучин нэгэн сая хоёр зуун арван таван мянга ная) ширхэг хүртэл.
2	Хувьцааг эргүүлэн худалдан авах захиалгын дээд үнэ	Монголын хөрөнгийн биржийн өмнөх өдрийн хаалтын ханшийн 15 (арван тав) хувь хүртэл.
3	Багц арилжааны худалдан авах ханшийн дээд хязгаар	Нийлбэр дүнгээрээ 250,000,000 (хоёр зуун тавин сая) төгрөгөөс дээш үнийн дүн бүхий багц арилжааны буурах хэлбэлзэл нь өмнөх өдрийн хаалтын ханшнаас 5 хувиас илүүгүй байх, өсөх хэлбэлзэл нь өмнөх өдрийн хаалтын ханшнаас 15 (арван тав) хувь хүртэл.
4	Хувьцааг эргүүлэн худалдаж авах үйл ажиллагааны үргэлжлэх хугацаа	2025 оны 06 сарын 16-ны өдрөөс 2025 оны 06 сарын 27-ны өдрийг дуустал байна.
5	Мэдээлэл хүргэх	Долоо хоног бүрийн Баасан гарагт тухайн долоо хоногт халаасалсан хувьцааны тоо, дундаж ханшийн талаарх мэдээллийг компанийн www.mandal.mn цахим хуудас болон Монголын хөрөнгийн биржийн www.mse.mn цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлнэ.



**“МАНДАЛ ДААТГАЛ” ХК-ИЙН ХУВЬЦААГ
ЭРГҮҮЛЭН ХУДАЛДАН АВЧ, ХАЛААСЛАХ ЖУРАМ**

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү журмаар “Мандал Даатгал” ХК (цаашид “Компани” гэх)-ийн гаргасан энгийн хувьцааг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтээс эргүүлэн худалдан авч, халааслах ажиллагааг зохицуулна.

2. ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖ

- 2.1 Энэхүү журам нь Монгол улсын Иргэний хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны бүртгэлийн журам, Монголын хөрөнгийн биржийн Арилжааны журам, Үнэт цаас гаргагчаас олон нийтэд хүргэх мэдээллийн журам болон холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд үйлчилнэ.

3. ҮЙЛЧЛЭХ ХҮРЭЭ

- 3.1 Энэхүү журам нь Монголын хөрөнгийн бирж дээр нээлттэй арилжаалагдаж буй Компанийн энгийн хувьцааг эргүүлэн худалдаж авах үйл ажиллагаанд үйлчилнэ.

4. ХУВЬЦААГ ЭРГҮҮЛЭН ХУДАЛДАЖ АВАХ НӨХЦӨЛ

- 4.1 Эргүүлэн худалдаж авах хувьцааны нийт хэмжээ нь Компанийн гаргасан нийт энгийн хувьцааны 5 (тав) хүртэл буюу 31,215,080 (гучин нэгэн сая хоёр зуун арван таван мянга наяд) ширхэг хувьцаанаас хэтрэхгүй.
- 4.2 Эргүүлэн худалдаж авах хувьцааны төлбөрийг үндэсний мөнгөн тэмдэгт болох төгрөгөөр гүйцэтгэнэ.
- 4.3 Эргүүлэн худалдаж авах үйл ажиллагааг дараах хязгаарын хүрээнд явуулна:
- 4.3.1 Эргүүлэн худалдан авах нэгж хувьцааны дээд үнэ нь өмнөх өдрийн хаалтын ханшнаас 15 (хорин тав) хувь хүртэл;
- 4.3.2 250,000,000 (хоёр зуун тавин сая) төгрөгөөс дээш үнийн дүн бүхий багц арилжааны буурах хэлбэлзэл нь өмнөх өдрийн хаалтын ханшнаас 5 хувиас илүүгүй байх, өсөх хэлбэлзэл нь өмнөх өдрийн хаалтын ханшнаас 15 (арван тав) хувь хүртэл.
- 4.3.3 Нэг өдөрт эргүүлэн худалдаж авах хувьцааны тоо Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн эргүүлэн худалдаж авахыг зөвшөөрсөн нийт энгийн хувьцааны 100 (нэг зуун) хувь хүртэл байна.
- 4.3.4 Хувьцааг эргүүлэн худалдаж авах үйл ажиллагааг 2025 оны 06 сарын 16-ны өдрөөс 2025 оны 06 сарын 27-ны өдрийг дуустал хугацаанд гүйцэтгэнэ.

5. ХУВЬЦААГ ЭРГҮҮЛЭН ХУДАЛДАЖ АВАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧИЙН БҮРЭН ЭРХ

- 5.1 Компанийн ТУЗ нь дараах бүрэн эрхтэй:
- 5.1.1 Энэхүү журамд нэмэлт, өөрчлөлт оруулах;
- 5.1.2 Энэхүү журмын дагуу эргүүлэн худалдаж авсан компанийн халаасны хувьцааг буцаан гүйлгээнд оруулах асуудлыг шийдвэрлэх;
- 5.1.3 Хувьцааг эргүүлэн худалдаж авах асуудлаар хяналт тавих, асуулт тавих, зөвлөмж гаргах, үүрэг даалгавар өгөх, зогсоох.
- 5.2 Компанийн Гүйцэтгэх захирал нь хувьцааг эргүүлэн худалдаж авахтай холбоотой дараах бүрэн эрхтэй:
- 5.2.1 Хувьцааг эргүүлэн худалдаж авах ажиллагааг ТУЗ-өөс олгосон бүрэн эрх, энэхүү журамд заасан хүрээнд удирдан зохион байгуулах;
- 5.2.2 Энэхүү журмын хэрэгжилт, эргүүлэн худалдаж авсан хувьцааны талаарх мэдээллийг тухай бүр ТУЗ-д тайлагнах;

- 5.2.3 Компани нь хувьцааг эргүүлэн худалдаж авах ажиллагаанд аливаа ашиг сонирхлын зерчил үүсэхээс сэргийлэх;
- 5.2.4 Хувьцааг эргүүлэн худалдаж авахтай холбоотой аливаа гэрээ хэлцэл байгуулах;
- 5.2.5 Хувьцааг эргүүлэн худалдаж авахтай холбоотой мэдээллийг олон нийтэд болон эрх бүхий этгээдэд мэдэгдэх, мэдээлэх, Компанийн хувьцаа эзэмшигчдэд заавар, зөвлөгөө өгөх, эргүүлэн худалдаж авсан хувьцааг Үнэт цаасны бүртгэлээс хасуулах, Үнэт цаасны бүртгэлийн мэдээлэлд өөрчлөлт оруулахтай холбоотой ажлыг тухай бүр зохион байгуулах.

6. ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ ХУГАЦАА

- 6.1 Энэхүү журам нь батлагдсан өдрөөсөө хүчин төгөлдөр үйлчилнэ.